



## **“Төслийн нэг ойлголт – ил тод байдал” чуулган**

2013 оны 5 сарын 21

### **Т.Мөнхбат**

*Оюу Толгой ХХК-ийн, Нөөцийн стратеги ба шинэчлэлийн хэлтэс, үйл ажиллагаа төслүүд хариуцсан дэд захирал*

Эрхэм хүндэт ноёд, хатагтай нараа, хүндэт төлөөлөгчид өө,

Оюу Толгой ХХК-ийн нэрийн өмнөөс энэхүү арга хэмжээнд оролцож, төслийн талаарх танилцуулга хийх боломж олгосонд талархаж байгаагаа илэрхийлье.

Би илтгэлдээ Оюу Толгой төсөл эхэлсэн түүхээс эхлээд өнөөдрийг хүртэл гаргасан амжилтын тухай мэдээлэл бэлтгэлээ. (Илтгэлийн хоёрдахь хэсгийг төслийн менежментийн системийн талаар АЙ ТИ –н хэлтсийн жишээн хэлтсийн менежер Тулга танилцуулах болно).

Оюу Толгой төсөл нь манай улсын түүхэн дэх хамгийн том, дэлхийн давцан дээр одоогийн байдлаар мега төслийн хэмжээнд орж байна. Бид ямар ч дэд бүтэцгүй говь нутагт ердөө 30 орчим сарын хугацаанд уул уурхайн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт зэсийн ил уурхай, баяжуулах үйлдвэрийг босгож чадлаа.

Манай төр засаг, хөрөнгө оруулагчдын тогтвортой түншлэлийн үр дүнд НҮБ-ын гишүүн 44 орны 18 мянга орчим инженер-техникийн ажилчид хамтран Өмнөговь аймгийн нутагт улсынхаа түүхэнд тэмдэглэхүйц томоохон амжилтад хүрсэн нь энэ билээ.

Оюу Толгойд анх бид арав гаруй жилийн өмнө геологи-хайгуулын ажил, судалгаа шинжилгээ эхлүүлж байхад тэр үед тааралдсан жижиг алга, бор толгод ийм агуу их зэсийн нөөцтэй болно гэж төсөөлөөгүй явжээ. Гэтэл өнөөдөр энэ нь төсөл болон олон нийтийн түн сонирхдог сэдвийн нэг болжээ.

ОТ–н бүлэг ордын хэмжээнд ордуудын судалгааны түвшнээс хамаарч зохих нөөц, баялгийн зэрэглэлийг тооцож ирээдүйд уурхай байгуулах олон шатны судалгааны ажлууд хийгдсэн. Үүнд: Ордын геологи-хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, нөөцийн тайлан, Урьдчилсан зураг төслийн судалгаа, ОАЦТ, Урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ зэрэг судалгааны тайлангууд орно.

Ордын нөөцийг зохих стандартын дагуу буюу МУ-ын Нөөц, баялгийн түр заавар, Канадын нөөцийн NI-43-101, Австралийн ЖОРЖ–р тооцсон. Эдгээр стандартыг хэрэглэснээр төслийг санхүүжүүлж, хөрөнгө оруулалтыг Монгол улс руу татах боломжууд бүрдэж ирсэн юм.

Оюу Толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээг 2009 оны сүүлчээр зурж, 2010 оны дунд үеэс Төслийн Нэгдүгээр Үе Шатны барилга, бүтээн байгуулалтын ажил эхлэж 100,000т/х хүчин чадалтай баяжуулах үйлдвэр, ил уурхай болон холбогдох дэд бүтцүүдийг барьж байгууллаад байна.

Оюу Толгой уурхайг Рио Тинто компанийн өндөр түвшний стандартаар удирдан зохион байгуулж, шинэ технологи, шинэ стандартыг Монголынхоо уул уурхайн салбарт нэвтрүүлж байна. Мөн бид

Монгол улсын хуулиудыг болон компанийн бодлого, стандарт болон журмуудыг зөв зохистой ёс суртахууны өндөр хэм хэмжээнд авч хэрэгжүүлж ирлээ.

Төслийн цар хүрээ, Техник, эдийн засгийн тооцоо гэхчлэн цаасан дээр байсан төслийг өнөөдөр бодит үйлдвэр болгон хөгжүүлсэн энэ хугацаанд 6.2 тэрбум орчим ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна.

Энэ хугацаанд өдөр тутам бараа бүтээгдэхүүн худалдан авч, хөрөнгө зарцуулж байсан хэдий ч үндэсний хэмжээнд нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжсэн олон үйл ажиллагааг явууллаа. Өөрөөр хэлбэл, орлого олж эхлээгүй, дандаа хасах баланстай хэдий ч үндэсний хэмжээнд нийгэм, соёл, эдийн засгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийж ирснээрээ Оюу Толгой төсөл өөрийн онцлогтой.

Оюу Толгойн барилгын ажил эхэлснээс хойш эдүгээ 870 сая гаруй ам.долларыг татвар, зээл, урьдчилгаа төлбөрийн хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлээ. Засгийн газар болон Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас шалгаруулсан 2012 оны хамгийн их татвар төлсөн аж ахуйн нэгжүүдийн жагсаалтын хоёрдугаарт Оюу Толгой ороод байна.

### **Энэ бол бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй, орлого олоогүй байх үедээ гаргасан үзүүлэлт юм.**

Хамгийн сүүлийн үеийн мэдээллээр манай нийт ханган нийлүүлэгчдийн 67 хувь нь үндэсний аж ахуйн нэгжүүд байгаа юм. Үндэсний аж ахуйн нэгж гэдэгт 50-иас дээш хувийг нь монгол иргэн эзэмшдэг хуулийн этгээдийг хэлж байгаа юм.

Бид 2010 оноос хойш 5 жилийн хугацаанд Засгийн газартай хамтран мэргэжлийн боловсролын салбарт 126 сая ам.долларын хөрөнгө оруулалтыг хийж эхлээд байна.

Үндэсний хэмжээнд 6600 мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, орон нутагт цоо шинээр Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн гурван төвийг барьж, дөрвөн төвийг өргөтгөн, тоног төхөөрөмжөөр хангах, мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, энэ салбарын багш нарын үр чадварыг сайжруулахад анхааран ажиллаж байна.

Манай улсад урьд өмнө нь ашиглаж байгаагүй, нарийн техник технологийг нэвтрүүлж байгаа уг техникийг угсрах, барьж байгуулах, ажиллуулах хүн хүчний бэрхшээл гарч байсан. Гэсэн хэдий ч төсөл дээр богино хугацаанд дотоод болон гадаадын нарийн мэргэжлийн инженер техникийн багийг ажиллуулж төслийн барилга, бүтээн байгуулалтыг амжилттай гүйцэтгээд байна.

2013 оны эхээр анхны зэсийн баяжмалаа үйлдвэрлэсэн. Ирэх 6 –р сард бид бүтээгдэхүүнээ зах зээлд экспортлохоор төлөвлөж байна. “ОТ-н Зэсийн баяжмал” гэсэн цоо шинэ брэнд, Монголд үйлдвэрлэсэн уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортод гаргахад ийнхүү бэлэн болоод байна.

Уурхайг барьж байгуулахад орон нутаг болон компанийн хооронд хамтын үр өгөөж бий болдог. Төсөл хэрэгжиж буй орон нутгийг хөгжүүлэхэд бидний зүгээс нэлээдгүй хөрөнгө оруулалт хийгээд байна.

Сургууль, эмнэлэг барьж, ундны усны хангамжийн дэд бүтцийг сайжруулж, эрүүл мэндийн хөтөлбөр хэрэгжүүлж, соёлын өвийг хадгалж, хамгаалах үйл ажиллагаанд бидний хөрөнгө оруулалт чиглэж уурхайтай хөрш зэргэлдээ орших нутаг орон, ард иргэдэд ашиг тусаа өгч байна.

Ус бол говь нутгийн хамгийн үнэт эрдэнэ. Тиймээс бид усны хэрэглээнд онцгой анхаарч чамгүй их хөрөнгө мөнгө зарцуулж байна.

Энэ ажлын хүрээнд усны хэмнэлт бүхий орчин үеийн уул уурхайн арга ажиллагаа, технологийг нэвтрүүлээд байна. Ахуйн хэрэглээний усны 100 хувийг, үйлдвэрт ашигласан усны 80 хувийг дахин боловсруулж ашигладаг.

Бид дэлхий дээр хамгийн усны өндөр хэмнэлт, хамгийн бага усны хэрэглээ бүхий зэсийн уурхайн нэг болох зорилт тавин ажиллаж байна.

Оюу Толгой төслийн Хоёрдугаар үе шатыг барьж байгуулах олон тэрбум ам.доллараар хэмжигдэх энэхүү санхүүжилт нь манай улсад эдийн засагт үр өгөөжөө оруулах юм. Дэлхийн шилдэг банк, санхүүгийн байгууллагын анхаарлыг Монгол руу татсанаар бид олон улсын хөрөнгө оруулалтыг татах тааламжтай орон гэдгээ бэхжүүлэхэд боломжтой юм.

Манай төр засаг болон хөрөнгө оруулагчид хамтран Оюу Толгой төслийг амжилттай хэрэгжүүлснээр уул уурхайн салбарын өгөөж нэмэгдэж эдийн засгийн өсөлт хөгжлийн шилдэг жишээ болгоно гэдэгт бид найдаж байна.

Оюу Толгой ил уурхайгаасаа 2013 оны хоёрдугаар хагасаас орлого олж эхлэх ч, газрын гүнд далд уурхайн бүтээн байгуулалт болох 250 км үрт нүхэн гарц, тунелийг барьж байгуулахын тулд ихээхэн хэмжээний хөрөнгө мөнгө босгох шаардлага гарч байна. Оюу Толгойн хүдрийн биетийн дийлэнх нь буюу нийт үр ашгийн 80 хувийг далд уурхайн аргаар олборлох юм.

Манай орны эрх ашиг, хамтрагч талуудын үр ашиг, байгаль орчныг хамгаалах талаар илүү өндөр түвшний стандартуудыг мөрдөж ажиллах ёстой бид ухамсарлан ажиллаж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.